

БАТЛАВ:
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА *(Signature)* М.БАДАМСҮРЭН

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗАСВАР, АРЧЛАЛТ,
ШИНЭЧЛЭЛТ, АВТО ЗАМ БАРИХ АЖЛЫН ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ,
ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

№: АЗТТХ/2024-01

№	Үйл ажиллагаа	Тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт
1	Төсөл хэрэгжүүлэх үндэслэл	Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төрөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт дахь XV.1.1.77 Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/, Зам, тээврийн хөгжлийн сайд (ТЭЗ)-ын 2024 оны “Эрх шилжүүлэх тухай” А/06 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан ажлын техник технологийн зөвлөх үйлчилгээний ажил -Техник технологийн хяналтын зардал: 327,289,706 төгрөг -Захиалагчийн хяналтын зардал: 16,364,486 төгрөг Нийт санхүүжих дүн: 343,654,192 төгрөг
2	Төслийн зорилго	Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ ажлын техник технологийн зөвлөх үйлчилгээний ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, инженер-геологийн судалгаа болон техникийн шаардлагыг дагуу хийж гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулан өдөр тутмын техникийн хяналт хийж төслийн явцын тайлан мэдээг бэлтгэн Захиалагчид ирүүлэхэд оршино. Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллана.
3	Үр дүн	Зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага нь авто замын барилгын ажлын явцад өдөр тутмын техник, техникийн хяналт тавьж ажилласнаар зам барилгын ажил чанартай бөгөөд гэрээт хугацаандаа ашиглалтад оруулах боломжтой болно.
4	Зөвлөх үйлчилгээний ажлын хамрах хүрээ	4.1. Зөвлөх үйлчилгээний хяналтын баг нь гүйцэтгэгч байгууллага тус ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, төслийн явцын тайлан мэдээ гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. 4.2. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18-ны 228 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг мөрдөн ажиллана. Зөвлөх нь замын барилгын ажилд уг журмын хавсралтад заасан жишиг маягтыг ашиглана.

(Signature)

		<p>4.3. Гүйцэтгэгчээр ажлын тодотгосон, нэгдсэн, дэлгэрэнгүй график гаргуулан хянаж, Захиалагчид танилцуулна.</p> <p>4.4. Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх төлөвлөгөө, ажиллах хүч, тоног төхөөрөмжийн нарийвчилсан төлөвлөгөөг хянаж батлах, Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн байдлыг газар дээр нь шалган, зохих тохиргоо зүгшрүүлэлт хийсэн, ажлын шаардлага хангасан эсэхийг батална.</p> <p>4.5. Гүйцэтгэгчийн зүгээс байгуулах хяналтын лабораторийн шаардлага хангаж буй эсэхийг шалгаж, ашиглах зөвшөөрөл олгож лабораторийн туршилт, шинжилгээний ажилд өдөр тутмын хяналт тавьж, шинжилгээний үр дүнг баталгаажуулж ажиллана.</p> <p>4.6. Гүйцэтгэгчийн чанарын хяналтын болон ажлын график төлөвлөгөөг батална.</p> <p>4.7. Гүйцэтгэгчийн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг хянан баталгаажуулна.</p> <p>4.8. Техникийн шаардлагын дагуу зам барилгын ажилд хэрэглэх материалуудын эх үүсвэрийг баталгаажуулж, зөвшөөрөл өгнө.</p> <p>4.9. Гүйцэтгэгчийн гаргасан газрын түвшин, төлөвлөсөн түвшин, хөндлөн огтлолын зураг, геодезийн хэмжилтийн үр дүнг шалган баталгаажуулж, ажил гүйцэтгэх зөвшөөрөл өгнө.</p> <p>4.10. Гүйцэтгэгчийн гаргасан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түр зам барих болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах төлөвлөгөөг гарган хянаж, батална.</p> <p>4.11. Зөвлөх нь ажлын явцад Гүйцэтгэгчийн хийсэн ажлын тоо хэмжээг геодезийн болон бусад хэмжилтийн багаж ашиглан хяналт хийж, тайлан гаргаж Захиалагчид хүргүүлнэ.</p> <p>4.12. Замын барилгын ажлын үе шат бүрийг өдөр бүр шалгаж дараагийн үе шат бүрийг өдөр бүр шалгаж дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэх зөвшөөрлийг бичгээр өгч байна.</p> <p>4.13. Замын тэмдэг болон бусад тоноглолыг суулгахаас өмнө зураг төсөл, техникийн шаардлагын дагуу урьдчилан хянаж батална.</p> <p>4.14. Зөвлөх нь батлагдсан ажлын зураг, техникийн шаардлагын дагуу зөвшөөрөгдсөн материал, тоног төхөөрөмж ашиглан ажил гүйцэтгэх технологийн дагуу барилга угсралтын ажлыг явуулж байгаа эсэхэд өдөр тутмын хяналтыг хийж тэмдэглэл хөтөлнө.</p> <p>4.15. Авто зам, замын байгууламжийн барилгын хэрэгжилтэд хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлж буй этгээд нь Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмын хавсралтад дурдсан жишиг маягтуудыг ашиглан хяналтын үйл ажиллагааг явуулна.</p> <p>4.16. Гүйцэтгэгчийн ажлын зураг, материал, хийц хэсэг, тоног төхөөрөмж, ажлын аргачлал өөрчлөгдөх бүрд Зөвлөх тэдгээрийг хянаж Захиалагчтай зөвшилцөж зөвшөөрөл олгоно.</p> <p>4.17. Ажлын бус амралтын цагаар болон илүү цагаар гүйцэтгэгч ажиллах хүсэлт гаргавал зөвлөх ажиллах үүрэгтэй.</p> <p>4.18. Барилгын ажлын явцад ажлын зураг, хийц, техникийн шаардлага зөрчих, батлагдаагүй материал, тоног төхөөрөмж ашиглах, батлагдсан аргачлалаас өөр аргаар ажил гүйцэтгэх бүрд Зөвлөх нь Гүйцэтгэгчийн ажлыг зогсоох үүрэг, эрхтэй. Ажил зогсоох шаардлагыг албан бичгээр өгнө.</p>
--	--	---

	<p>4.19. Зөвлөх нь долоо хоног, сарын эхээр Гүйцэтгэгчтэй хамтран талбайн уулзалт хийх бөгөөд энэ уулзалтаар долоо хоногт болон сард төлөвлөсөн ажлын явц, гүйцэтгэл, ажлын чанар, ажлын графикийн өөрчлөлт зэрэг барилга угсралтын ажлын явцтай холбоотой асуудлуудыг хэлэлцэх ба уулзалт бүрийн тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулна. Онцгой нөхцөл байдал үүссэн тухай бүрд уулзалт зохион байгуулж болно.</p> <p>4.20. Зөвлөх нь аливаа асуудлыг Захиалагчаар дамжуулан холбогдох байгууллагуудтай албан бичгээр аливаа асуудлыг шийдвэрлэж байна.</p> <p>4.21. Гүйцэтгэгчийн хийсэн ажил нь чанарын шаардлага хангаагүй бол түүнийг дахин хийлгэх, засварлуулах зэрэг арга хэмжээг тухай бүрд авах бөгөөд ийм ажилд төлбөр хийгдэхгүй.</p> <p>4.22. Зөвлөх нь зураг төсөл, барилга, байгууламжийн аливаа ажлын өөрчлөлт гарахаар бол Эрх бүхий этгээдэд танилцуулах үүрэг, эрхтэй боловч гэрээний үнийн дүнгийн 10%-иас доош өртөг бүхий ажлын өөрчлөлтийг Зөвлөх инженер бие даан шийдэх эрхтэй. Зөвлөх инженерийн эрх, үүргийн тухай зөвлөхийн гэрээнд нарийн тусгаж өгнө.</p> <p>4.23. Зөвлөх нь барилгын ажлын явцын тайланг сар бүр гарган Захиалагчид ирүүлэх үүргийг хүлээнэ. Тайланд ажлын явц, ажлын явцад гарсан аливаа өөрчлөлтийн асуудал, цаашид авах арга хэмжээний талаар холбогдох фото зураг, график, тооцооны хамт танилцуулж байна. Барилгын ажил дууссаны дараа Зөвлөх нь төгсгөлийн тайлан гаргаж, Захиалагчид хүргүүлнэ.</p> <p>4.24. Гүйцэтгэгч гэрээний заалтуудыг зөрчиж, гэрээт хугацаандаа ажлаа дуусаагүй бол Зөвлөх гэрээний зохих заалтын дагуу гэрээний торгууль ногдуулах санал гаргаж Захиалагчид танилцуулах үүрэгтэй бөгөөд торгууль ногдуулах асуудлыг Захиалагч шийдвэрлэн Зөвлөхөд мэдэгдэнэ.</p> <p>4.25. Гүйцэтгэгч гэрээт хугацаандаа ажлаа дуусгаж чадахгүй, ажлыг чанартай хийж гүйцэтгэх чадваргүй зэрэг асуудал тодорхой болсон нөхцөлд Зөвлөх нь гүйцэтгэгчийн гэрээг цуцлан өөр Гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч авах зэрэг саналаа Захиалагчид танилцуулна. Гэрээ цуцлах, өөр гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч нэмж авах асуудлыг Захиалагч шийдвэрлэнэ.</p> <p>4.26. Гүйцэтгэгч байгууллага ажлаа дуусган барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссоор ажлаа хүлээлгэж өгсний дараа Зөвлөх нь барилгын ажил дууссан тухай тайлан гаргаж, Захиалагчид хүргүүлнэ.</p> <p>4.27. Гүйцэтгэгчийн гэрээнд заасан баталгаат хугацаа дууссаны дараа Зөвлөх нь замын ашиглалтын байдлыг хянан үзэж, ажлын чанар муугаас болж гарсан эвдрэлийг Гүйцэтгэгчээр засуулан эцсийн тайлан гаргаж, барьцааны болон буцаах мөнгийг Гүйцэтгэгч байгууллагад эргүүлэн төлөх хүсэлтийг Захиалагчид гаргана.</p> <p>4.28. Баталгаат засварын хугацаа дуусах үед авто замын байдал болон Гүйцэтгэгчийн хийх шаардлагатай засварын ажлын талаар Захиалагчид танилцуулна.</p> <p>4.29. Зөвлөх нь барилгын ажил дууссаны дараа авто зам, замын байгууламжийг хүлээж авахад Захиалагчид мэргэжлийн тусалцаа үзүүлнэ.</p>
--	--

		4.30. Зөвлөх нь Захиалагчтай байнгын харьцаатай байж бүх талын мэдээллээр хангана.
5	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчид тавигдах шаардлага	<p>5.1. Зөвлөх нь “Авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”-д заасан нөхцөл шаардлагыг хангасан тусгай зөвшөөрөлтэй Монгол Улсын хуулийн этгээд байна.</p> <p>5.2. Зөвлөх нь Захиалагчийн тавьсан шаардлагыг хангасан бүрэлдэхүүнтэй хяналтын багийг томилж, ажлын талбайд байнга ажиллуулна. Зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан мэргэжилтнийг өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд Захиалагчтай зөвшилцөн, зөвшөөрөл авсны үндсэн дээр түүнтэй ижил түвшний мэдлэг боловсрол, туршлагатай түүнийг томилон ажиллуулна.</p> <p>5.3. Хяналтын багийн ажилтнуудын амьдрах байр, тэдгээрийн тавилга, хэрэгсэл, компьютер, албан конторын бусад тоног төхөөрөмж, талбайд болон бусад этгээдтэй шуурхай холбоо барих хэрэгсэл, зам барилгын ажлын лаборатори, геодезийн багаж, хэрэгсэл, ажлын хувцас, машин техник, гэх мэт ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх ба тээвэр, холбоо, цахилгаан, дулаан, бичиг хэрэг, ахуйн хангамж, зэрэг гарах зардлуудыг Зөвлөх өөрөө бүрэн хариуцна.</p> <p>5.4. Хяналтын багийн бүх мэргэжилтнүүд урьдчилан гаргасан ажлын хуваарийн дагуу барилгын ажлын талбайд байнга ажиллах шаардлагатай.</p> <p>5.5. Зөвлөх нь ямар ч тохиолдолд захиалагчийн эрх ашгийг хамгаалан мэргэжлийн өндөр түвшинд хичээл зүтгэлтэй, үр дүнтэйгээр ажиллах ба гэрээт ажлын хэрэгжилтийн явцад гаргах бүх зардлыг аль болох хамгийн бага хэмжээнд байлгах, төслийг чанартай хэрэгжүүлэх шаардлагатай бүх алхмыг хийж Захиалагчийн хүсэлтээр гэрээт ажилтай холбоотой бүх талын мэдээллийг гаргаж өгнө.</p>
6	Хугацаа	<p>6.1. Захиалагч болон Зөвлөхийн хооронд зам барилгын ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж барилгын ажил эхлэх өдрөөс Зөвлөх үйлчилгээний ажил эхэлж барилгын ажлын баталгаат хугацаа дууссанаар гэрээний хугацаа дуусгавар болно. Захиалагч болно Зөвлөхийн хооронд байгуулах гэрээнд хугацааг тодорхой тусгах бөгөөд гэрээнд заасан төлбөрт багтаан Зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.</p> <p>6.2. Зөвлөхийн хяналтын баг нь авто замын барилгын ажил үргэлжлэх хугацаанд ажиллах ба барилгын ажил дууссаны дараа улсын комисс ашиглалтад хүлээн авах хүртэл, мөн баталгаат хугацааны үед тус тус ажиллана.</p>
7	Тайлангийн хуваарь	<p>7.1. Эхлэлийн тайлан: Зөвлөх үйлчилгээний ажил эхэлснээс хойш 1 сарын дотор ирүүлэх бөгөөд цаашдаа сар бүр Захиалагчид хүргүүлнэ. Мөн 7 хоног тутамд гүйцэтгэлийн явцын мэдээллийг фото зургаар баталгаажуулан цахимаар Захиалагчид хүргүүлж байна.</p> <p>7.2. Сар, улирал тутмын явцын тайлан: Зөвлөх нь барилгын ажлын явцын тайланг сар бүр, улирал тутам гарган Захиалагчид</p>

		<p>ирүүлнэ. Тайланд барилгын ажлын явц, чанар байдал, ажлын явцад гарсан аливаа өөрчлөлтийн талаар, цаашид авах арга хэмжээний талаар холбогдох фото зураг, график, тооцооны хамт танилцуулна.</p> <p>7.3. Гүйцэтгэлийн тайлан: Зөвлөх нь авто замын барилгын ажил дууссаны дараа гүйцэтгэлийн тайлан бичиж Захиалагчид хүргүүлнэ.</p> <p>7.4. Төслийн эцсийн тайлан: Барилгын ажлын баталгаат хугацаа дуусгавар болсноор авто замын барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ дуусгавар болсонд тооцон төслийн эцсийн тайлан бичиж Захиалагчид хүлээлгэн өгнө.</p>
8	Хугацаа	<p>8.1. Монгол орны эрс тэс цаг агаарын нөхцөл болон тухайн бүс нутгийн онцлогоос шалтгаалан барилгын ажлын улирал гол төлөв 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарыг дуустал 7 сар үргэлжлэх боломжтой. Барилгын ажлын гэрээг 1 жилд гурван улирлаар төлөвлөх нь зүйтэй.</p> <p>8.2. Зөвлөх нь ажиллах хүчний бүрэлдэхүүн болон ажлын графикийг тусгасан барилгын хяналтын зөвлөх үйлчилгээний техникийн санал болон гэрээний үнийн саналаа танилцуулна.</p> <p>8.2.1. Техникийн саналд дараах зүйлүүд багтана.</p> <ul style="list-style-type: none"> - Зөвлөх компанийн ажлын туршлага, хүчин чадал. - Зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хяналт хийх тогтолцоо, схем. - Зам барилгын ажилд хяналт хийх зөвлөх инженерүүдийн нэрсийн жагсаалт, тэдгээрийн анкет. - Зөвлөх үйлчилгээ хийх аргачлал. - Зөвлөх инженерүүдийн ажиллах ажлын график. <p>8.2.2. Гэрээний үнэд дараах зардлууд багтсан гэж үзнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Хяналтын багийн цалин хөлс. Үүнд: ажилтнуудын цалин хөлс, бүсийн нэмэгдэл, татвар даатгалууд, байгууллагын удирдлагын болон нэмэгдэл зардал ба ашиг. - Хяналтын багийн томилолт, хээрийн нэмэгдэл зардал. - Хяналтын багийн ашиглах компьютер, принтер, сканнер бусад техник хэрэгслийн зардал. - Харилцаа холбооны зардал. Үүнд: Хяналтын багийн хоорондоо болон удирдлага, захиалагчтай ямар ч цаг үед шуурхай холбоо барих утсан болон интернэт холбоотой байх. - Тээврийн зардал. Үүнд: Хяналтын баг Улаанбаатараас ажлын талбайд очих болон ирэх зардал /Түрээс бол түрээсийн үнэ орсон байна/ өдөр бүр талбайд ажиллах шатах, тослох материалын үнэ болон жолоочийн улин хөлс гэх мэт орно. Хяналтын баг нь дунджаар 0-20 км хүртэлх зам дээр 2500 см3-ээс багагүй цилиндрийн багтаамж бүхий 2-оос доошгүй авто машинтай байна. - Ажлын болон амьдрах байрны зардал. Үүнд: Хяналтын баг ажлын талбайн ойролцоо амьдрах болон ажлын байр байгуулах, эсвэл түрээслэх мөн шаардлагатай тавилга хэрэгслээр хангах тэдгээрийн харуул хамгаалалт, цэвэрлэгээ, үйлчилгээний зардал болон ашиглалт, засвар үйлчилгээний зардал. - Сар улирлын тайлан бэлтгэн гаргах, тэдгээрийг хэвлэн олшруулах зардал. - Төслийн захирал жилд 3-аас доошгүй удаа ажлын талбайд очин хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч ажиллах үеийн зардал.

		<p>8.3. Ажлын цар хүрээ болон барилгын ажлын хяналтын хугацаа өөрчлөгдвөл тухайн үед Захиалагчид мэдэгдэн гэрээнд өөрчлөлт оруулна.</p> <p>8.4. Замын бүх төрлийн ажилд шаардагдах лабораторийн тоног төхөөрөмжийн хангамж, тэнд ажиллах туслах ажилтнуудын цалин хөлс бусад зардлыг гүйцэтгэгч байгууллага бүрэн хариуцан ажиллана. Мөн гүйцэтгэгчийн ажлыг шуурхай явуулах үүднээс хяналтын баг нь замын далан, суурийн нягтралыг шуурхай тодорхойлох багажтай байж болно.</p>
--	--	--

**АВТО ЗАМ ДЭЭР АЖИЛЛАХ
ХЯНАЛТЫН БАГИЙН ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

№	Албан тушаал, ажилтны тоо	Тоо	Мэргэжил боловсрол	Туршлага
1	Төслийн удирдагч	1	Авто замын инженер	Зам барилгын ажилд 10 жил, үүнээс 8-аас доошгүй жилд нь зураг төсөл болон хяналтаар ажилласан зөвлөх инженер байх.
2	Хяналтын багийн ахлагч	1	Авто зам, гүүрийн инженер	Зам барилгын ажилд 10 жил, үүнээс 8-аас доошгүй жилд нь зураг төсөл болон хяналтаар ажилласан мэргэшсэн инженер байх.
3	Авто замын инженер	1	Авто замын инженер	Зам барилгын ажилд 8 жил, үүнээс 5-аас доошгүй жилд нь хяналтаар ажилласан зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй байх.
4	Хиймэл байгууламжийн инженер	1	Авто зам, гүүрийн инженер	Зам барилгын ажилд 5 жил, үүнээс 3-аас доошгүй жилд нь хяналтаар ажилласан зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй байх.
5	Материалын инженер	1	Авто зам, гүүрийн инженер	Зам барилгын ажилд 5 жил, үүнээс 3-аас доошгүй жилд нь хяналтаар ажилласан мэргэшсэн байх.
6	Хэмжилтийн инженер	1	Авто зам, гүүрийн инженер	Зам барилгын ажилд 5 жил, үүнээс 3-аас доошгүй жилд нь хяналтаар ажилласан зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй байх. Эсвэл геодезийн инженер мэргэшсэн байх

ТАНИЛЦСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

М.НЯМСҮРЭН

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

А.ТҮМЭНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДЭД БҮТЭЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.УРАНСҮХ